



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/27/СТА-ТШЗ



Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг: tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.8.2	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
	байхгүй .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	12
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
3.4	АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН .....	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.12 № 2/11  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Жинст сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Жинст сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Жинст сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох

2019 on gerchilgee JINST\_Sum ITH - .docx

2518485

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

---

### **2.1 Оршил**

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга М.Ган-эрдэнэд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.31-нээс 2019.02.02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр 2018.11.07-ны өдрийн 1/133 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Жинст сумын ИТХ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Жинст сумын ИТХ нь Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж, бие даан шийдвэрлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Баянхонгор Жинст сумын ИТХ-ын “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын анхан шатны нэгж болсон Багийн ИНХ-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төлөөлөгчдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажил хариуцах чадамжийг сайжруулах, төлөөллийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах.” зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Жинст сумын ИТХ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Жинст сумын ИТХ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс

үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Жинст сумын ИТХ санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Жинст сумын ИТХ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ” хангамж ашигладаг байна.

Жинст сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Жинст сумын ИТХ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Жинст сумын ИТХ-ын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 48594,5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 971.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

### **2.8.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал**

- Ажиллагсдын цалин хөлстэй холбоотой НДШ-ийн авлага 13.3 мянга, ХХОАТ-ын өглөг 33.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан.
- 2018 оны 3-р улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар НДШ-ийн өглөгийг 733.3 мянга, Багийн иргэд нийтийн хурлын даргын урамшуулалт цалингийн өглөг 1672.4 мянга, ХХОАТ-ын өглөгийг 367.4 мянга, ҮЭ-ийн өглөгийг 50.3 мянга төгрөгөөр тус тус дутуу тусгаж, цалингаас суутгасан хогны хураамжийн үнэ 75.0 мянган төгрөгийг шилжүүлээгүй байхад өглөгөөр тусгаагүй байна. 2018.05.18-ны өдөр цалингаас суутгасан 63,9 мянган

төгрөгийн ХХОАТ-ыг сумын орлогын 100030500911 дансанд төвлөрүүлсэн зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулсан.

Аудитын явцад хийсэн дээрх залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### **2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудал байхгүй.

### **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

байхгүй

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Жинст сумын ИТХ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд орон нутгийн төсвөөс 48266,6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж бүрэн авч, оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 991.3 мянган төгрөгийн орлогыг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Жинст сумын ИТХ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 24 мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Жинст сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/ төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>125,000.00</u></b>	<b><u>125,000.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	125,000.00	125,000.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	125,000.00	125,000.00
35110	Тусгай зориулалттай материал	125,000.00	125,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,112,245.65</u></b>	<b><u>784,332.85</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,112,245.65	784,332.85
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,112,245.65	784,332.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,440,550.00	9,440,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,440,550.00	-9,440,550.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,333,850.00	5,333,850.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,303,937.28	-5,333,850.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,235,000.00	8,235,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,152,667.07	-7,450,667.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	495,000.00	495,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-495,000.00	-495,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,237,245.65</u></b>	<b><u>909,332.85</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,237,245.65</u></b>	<b><u>909,332.85</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,237,245.65	909,332.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	18,854,420.00	18,854,420.00
51101	Өмч: - төрийн	18,854,420.00	18,854,420.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-17,749,774.35	-18,077,687.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-17,749,774.35	-17,749,774.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-327,912.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	132,600.00	132,600.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,237,245.65</u></b>	<b><u>909,332.85</u></b>

#### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

төгрөг

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>71,609,500.00</b>	<b>48,266,600.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>71,609,500.00</b>	<b>48,266,600.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	70,109,500.00	48,266,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,109,500.00	48,266,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>72,163,370.89</b>	<b>48,594,512.80</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>72,163,370.89</b>	<b>48,594,512.80</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	66,551,433.89	47,603,233.80
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	38,466,009.00	33,897,483.00
210101	Үндсэн цалин	37,926,009.00	33,897,483.00
210104	Урамшуулал	540,000.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,921,794.00	3,955,238.00
210201	Тэтгэврийн даатгал	3,921,794.00	3,955,238.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,105,220.00	4,042,100.00
210401	Бичиг хэрэг	531,720.00	747,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,673,000.00	3,144,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	370,000.00	150,000.00
210404	Ном, хэвлэл	260,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	270,000.00	00.00
2105	<b>Нормативт зардал</b>	2,548,300.00	00.00
210502	Хоол, хүнс	2,548,300.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,165,740.00	00.00
210604	Урсгал засвар	1,165,740.00	00.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,189,000.00	1,428,000.00
210702	Дотоод албан томилолт	2,189,000.00	1,428,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,155,370.89	4,280,412.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,094,900.00	2,694,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,381,600.00	1,258,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	678,870.89	327,912.80
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,611,937.00	991,279.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,611,600.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	00.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	337.00	991,279.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	337.00	991,279.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-553,870.89</b>	<b>-327,912.80</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-553,870.89</b>	<b>-327,912.80</b>

**3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
СТ-3А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>72,915,500.00</b>	<b>48,266,600.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	1,306,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>71,609,500.00</b>	<b>48,266,600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	1,500,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	70,109,500.00	48,266,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /	70,109,500.00	48,266,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>72,915,500.00</b>	<b>48,266,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>72,915,500.00</b>	<b>48,266,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>67,303,563.00</b>	<b>47,275,321.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	39,759,655.00	33,620,590.00
210101	Үндсэн цалин	34,839,797.00	30,145,167.00
210104	Урамшуулал	4,919,858.00	3,475,423.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,934,148.00	4,232,131.00
210201	Тэтгэврийн даатгал	3,934,148.00	3,672,767.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	145,937.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	135,247.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	6,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	271,780.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,358,220.00	3,979,600.00
210401	Бичиг хэрэг	696,720.00	660,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,698,000.00	2,919,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	345,000.00	400,000.00
210404	Ном, хэвлэл	385,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,233,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,643,300.00	00.00
210502	Хоол, хүнс	1,643,300.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	336,440.00	00.00
210604	Урсгал засвар	336,440.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,189,000.00	1,428,000.00
210702	Дотоод албан томилолт	2,189,000.00	1,428,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,082,800.00	4,015,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,078,900.00	2,615,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,003,900.00	1,400,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,611,937.00</b>	<b>991,279.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,611,600.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	00.00

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	337.00	991,279.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	337.00	991,279.00
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
СТ-4А

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,854,420.00	132,600.00	-17,749,774.35	1,237,245.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,854,420.00	132,600.00	-17,749,774.35	1,237,245.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-327,912.80	-327,912.80
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,854,420.00	132,600.00	-18,077,687.15	909,332.85

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан  
ТГ

төгрөг

Эдийн	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
-------	----------	-----------	-------------

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	70,109,500	70,109,163	48,266,600	47,275,321
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	70,109,500	70,109,163	48,266,600	47,275,321
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	64,497,900	64,497,563	48,266,600	47,275,321
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	38,790,400	38,790,296	34,542,700	33,620,590
210101	Үндсэн цалин	33,870,400	33,870,834	31,067,300	30,145,167
210104	Урамшуулал	4,920,000	4,919,912	3,475,400	3,475,423
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,936,900	3,936,807	4,301,300	4,232,131
210201	Тэтгэврийн даатгал	3,936,900	3,936,807	4,301,300	3,672,767
210202	Тэтгэмжийн даатгал	-	-	-	145,937
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	-	-	135,247
210204	Ажилгүйдлийн даатгал	-	-	-	6,400
210205	Эрүүл мэндийн даатгал	-	-	-	271,780
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,308,800	6,308,720	3,979,600	3,979,600
210401	Бичиг хэрэг	696,800	696,720	616,700	660,300
210402	Тээвэр, шатахуун	3,698,000	3,698,000	2,919,300	2,919,300
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	345,000	345,000	443,600	400,000
210404	Ном, хэвлэл	336,000	336,000	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,233,000	1,233,000	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	1,643,300	1,643,300	-	-
210502	Хоол, хүнс	1,643,300	1,643,300	-	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	336,500	336,440	-	-
210604	Урсгал засвар	336,500	336,440	-	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,189,000	2,189,000	1,428,000	1,428,000
210702	Дотоод албан томилолт	2,189,000	2,189,000	1,428,000	1,428,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,293,000	11,293,000	4,015,000	4,015,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,075,000	3,075,000	2,615,000	2,615,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,218,000	8,218,000	1,400,000	1,400,000

Жинст сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,611,600	5,611,600	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,611,600	5,611,600	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600	5,011,600	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000	600,000	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	70,109,500	70,109,163	48,266,600	47,275,321
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	70,109,500	70,109,163	48,266,600	47,275,321
132001	Орон нутгийн төсвөөс	70,109,500	70,109,163	48,266,600	47,275,321
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	3	3	3	3
620001	Удирдах ажилтан	2	2	2	2
620003	Үйлчлэх ажилтан	1	1	1	1
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>3</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1	1	1
650010	Гэрээт ажилтан	1	1	1	1
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	1	1